

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 757.2 сая төгрөг орж төлөвлөгөө 20.1 хувиар биелж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 405.7 саяар дээгүүр гүйцэтгэлтэй байна. Сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 2.8 хувиар тасарч, Баяндэлгэр, Наран, Онгон, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Түмэнцогт, Уулбаян сумдын төлөвлөгөө давж биелэсэн байна.

Орон нутгийн зарлага санхүүжилт 663.3 сая төгрөг болж төлөвлөгдсөн хэмжээнээс 32.6 сая төгрөгөөр давж биелэсэн байна.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Монгол шуудан, Хас банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 13 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн хадгаламжийн хэмжээ 7.9 тэрбум болж, 2009 оны жилийн эцсийн үлдэгдлээс 0.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. Аймгийн хэмжээгээр нийт 27 тооцооны төв ажиллаж байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Мал аж ахуй: Оны эхний малын 0.31 хувь болох 5.5 мянган толгой мал зүй бусаар хорогдсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 5.0 дахин буюу 4.4 мянган малаар дээгүүр байна.

Түмэнцогт, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Асгат, Мөннххаан сумдад оны эхний малын 1.01 - 0.4 хувь нь зүй бусаар хорогдсон нь хамгийн их нь бөгөөд Наран сумд хорогдолгүй байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР : Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 5.6 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Оны үнээр 23.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 20.7 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт урьд оны мөн үеийнхээс өссөн үзүүлэлттэй байна.

V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифийн ерөнхий индекс 2009 оны жилийн

эцсийнхээс 4.7 хувиар өсөхөд хүнсний барааны үнэ 11.2 хувиар, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисны үнэ 1.1 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.2 хувиар, эм тариа эмнэлгийн үйлчилгээний үнэ тариф 1.2 хувиар өссөн нь тус тус нөлөөлжээ. Өнгөрсөн оны мөн үеэс үнэ тарифын ерөнхий индекс 4.7 хувиар өсчээ.

VI. ЭРҮҮЛ МЭНД: Эхний 2 сард 198 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үеэс 10 эхээр олон байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 7 байгаа нь урьд оны мөн үеэс дээгүүр байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 88 болж урьд оны мөн үеэс Сүрьеэ, Заг, Трихоминиаз, Салхинцэцэг, тэмбүү өвчнөөр өвчлөгчдийн тоо өсч, бусад халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо буурсан байна.

VII. АЖИЛГҮЙЧҮҮД: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1122 болж, урьд оны мөн үеийнхээс 29.9 хувиар өссөн байна. Ажилгүйчүүдийн 65.8 хувь нь 16-34 насны залуучууд, 19.1 хувь нь дээд, 5.5 хувь нь тусгай дунд, 37.1 хувь нь бүрэн дунд, 7.2 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна. 80 хүн шинээр бүртгүүлж, 161 хүн ажилд орсон байна.

VIII. ГЭМТ ХЭРЭГ: Эхний 2-р сард 25 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 12- оор доогуур байна.

Гэмт хэргийн улмаас 7 хүн нас барж, 9 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 3.7 сая төгрөгийн хохирол учирсны 1.9 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 19 хүн холбогдон сэжиглэгдсэний 21.0 хувь нь согтуугаар, 21.0 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 326 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 102 хүнээр доогуур байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 23 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 7 хүнээр доогуур байна.

Хэрэг илрүүлэлт 100 хувьтай байна.